

АУДИТЫН КОД: САГ-2018/04/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Уянга

Утас: 261628 Цахим хаяг: uyangab@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1.	Аудитын хураангуй тайлан	2
2.	Аудитын гэрчилгээ	4
3.	Аудитын тайлан.....	6
3.1.	Оршил	6
3.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
3.3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
3.4.	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
3.5.	Дотоод аудит	8
3.6.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
3.7.	Шилэн дансны мэдээлэл	9
3.8.	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	9
3.9.	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
3.10.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
3.11.	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	10
3.12.	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	10
3.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.14.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	10
3.15.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3.16.	Үр өгөөжийн тооцоолол	11
4.	Менежментийн захидал.....	12
	Үндсэн хөрөнгө	13
5.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	14
5.1.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
5.2.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	15
5.3.	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5.4.	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
5.5.	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5.6.	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА Х.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2018.04.25 № 1020
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт


Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




070400

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3. Аудитын тайлан

3.1. Оршил

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Авлигатай тэмцэх газрын дарга Х.Энхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Авлигатай тэмцэх газрын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (цаашид УСНББОУС гэх), нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Уянга нар хариуцаж хэрэгжүүлэв.



Авлигатай тэмцэх газрын дарга 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/2833 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Авлигатай тэмцэх газрын дарга Монгол Улсын Авлигын эсрэг хуулиар тогтоосон дор дурдсан чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Хуульд заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах ажлыг зохион байгуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх зэрэг болно.

Авлигатай тэмцэх газрын дарга тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Улсын Их Хурлаас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 70 арга хэмжээ төлөвлөснөөс 98 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №1. Авлигатай тэмцэх газрын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт


Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2017 оны зорилтот түвшин	Биелэлт	Хувь
Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар хянагдсан хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо	3200	2689	84%
Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааны тоо	6	6	100%
Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/	15.0	24.7	165%
Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа	1	1	100%
Хүүхдийн шударга байдлын судалгаа	1	1	100%
Шударга байдлын үнэлгээ	1	1	100%
Шударга ёс эмхэтгэл	4	4	100%
Авлигын гэмт хэргийн баримтын судалгаа	1	1	100%
Байгууллага, иргэдийн гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх /хувиар/	98.0	98.4	100%
Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан гомдол, мэдээллийн шинжилгээ	12	12	100%

Эх сурвалж: shilendans.gov.mn

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан болно.

3.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгосон.



Аудитаар Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна удирдлагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 11 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 43 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Авлигатай тэмцэх газар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2014 онд боловсруулж баталсан, 2015 онд тус газрын даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан боловч Сангийн яамнаас 2017 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах асуудлыг дэлгэрэнгүй тусгахгүй байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал зэрэг болно.

Авлигатай тэмцэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

3.5. Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэсэн заалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагч дотоод аудитын алба байгуулаагүй, дотоод аудиторын орон тоо байхгүй байна.



3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Авлигатай тэмцэх газрын даргын 2017 онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 7 үзүүлэлтээр баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 10,402.8 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 9,551.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 851.4 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 10,350.6 сая төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал зардалд 9,499.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 52.2 сая төгрөгөөр дутуу, хөрөнгийн зардалд 851.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 851.4 сая төгрөг батлагдаж, тайлант онд гүйцэтгэлээр 851.4 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад олгосон байна.

Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлыг ерөнхий ангиллаар хэтрүүлэн зарцуулаагүй байна.

Нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц сангаас 50.0 сая төгрөг, Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 24.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу түрээсийн орлого 25.2 сая төгрөг нийт 99.2 сая төгрөг төвлөрснийг бүрэн зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Авлигатай тэмцэх газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Тус газар өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт (бүтэн жилээр);
- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр);
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр);
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр);
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр) зэрэг болно.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд тус газартай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 43 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэдэг 2 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулахад дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт хэсэгт дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед үндсэн хөрөнгийн өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнд: а) аж ахуйн нэгжид ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авчрах боломжтой байх; болон б) хөрөнгийн өртгийг үнэн зөв хэмжих боломжтой байх” гэсэн шалгуурыг хангаж буй 40.7 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөнд бүртгэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал хандуулах бусад асуудал түүвэрлэн үзсэн горимын хувьд байхгүй байна.

3.11. Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд 2018 оны завсрын аудитаар урьдчилгаа данс, урьдчилж төлсөн зардлын дансны тайлант хугацаан дахь хүлээн зөвшөөрөлтөд нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 40.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэнд 1 зөвлөмж хүргүүллээ.


3.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Авлигатай тэмцэх газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 03/4606 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу төрийн аудитын байгууллага суурийг тооцохдоо 2016 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардлын дүнг сонгосон ба 2017 оны гүйцэтгэлээрх үр дүнгээс



өндөр байгаа нь илэрсэн зөрчлийг үнэлэхэд хүлээн зөвшөөрөгдөх түвшинд нөлөөлөх тул гүйцэтгэлээрх нийт зардлын дүнг сонголоо.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,361.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 187.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

3.15. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16. Үр өгөөжийн тооцоолол

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үр өгөөж тооцоологдоогүй болно.



4. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Авлигатай тэмцэх газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Авлигатай тэмцэх газрын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



Үндсэн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
<p><u>ҮАГ-ын ажиглалт</u></p> <p>УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт хэсэгт дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед үндсэн хөрөнгийн өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнд: а) аж ахуйн нэгжид ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авчрах боломжтой байх; болон б) хөрөнгийн өртгийг үнэн зөв хэмжих боломжтой байх.” гэсэн шалгуурыг хангаж буй 40.7 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.</p>	<p><u>ҮАГ-ын зөвлөмж</u></p> <p>Бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэх</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p>
<p><u>Эрсдэлүүд</u></p> <p>Хөрөнгө алга болох, шамшигдах Тайлант оны зардал буруу илэрхийлэгдэх</p>	<p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>Зөвлөмжийн дагуу хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэх бүртгэхийг хүлээн зөвшөөрсөн.</p>



5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,210,147.3	5,499,899.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,233,636.7	2,136,194.2
АВЛАГА	-	7.7
УРЬДЧИЛГАА	117,488.6	567,489.8
БАРАА МАТЕРИАЛ	2,859,022.0	2,796,208.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,998,549.0	8,013,083.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,998,549.0	8,013,083.4
Биет хөрөнгө	6,942,669.0	7,836,231.2
Биет бус хөрөнгө	55,880.0	176,852.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,208,696.3	13,512,983.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,226,592.2	2,135,192.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,226,592.2	2,135,192.2
Урьдчилж орсон орлого	2,226,592.2	2,135,192.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,982,104.1	11,377,790.9
Засгийн газрын хувь оролцоо	9,982,104.1	11,377,790.9
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,489,727.6	1,489,727.6
Хуримтлагдсан үр дүн	8,492,376.5	9,888,063.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,208,696.3	13,512,983.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,112,642.5	10,515,838.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	407,446.0	120,802.00
Нийтлэг татварын бус орлого	248,042.8	19,600.8
Тусламжийн орлого	159,403.2	101,201.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,705,196.5	10,395,036.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,500,158.8	9,338,843.8
УРСГАЛ ЗАРДАЛ	9,500,158.8	9,338,843.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,311,967.2	9,080,409.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,683,458.5	3,898,825.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,869.0	261,753.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,000.0	96,286.7
Хангамж, бараа материалын зардал	180,576.1	196,443.5
Нормативт зардал	4,347.0	4,086.5
Эд хогшил, урсгал засварын зардал	36,484.3	48,584.6
Томилолт, зочны зардал	81,541.7	82,728.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,526,251.4	3,092,204.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,466,439.2	1,399,495.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,191.6	258,434.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(387,516.3)	1,176,994.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	19,486.4	220,067.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,759.9	1,375.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(370,789.8)	1,395,686.8



5.3. Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,027,655.3	0.0	11,027,655.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(674,761.4)	0.0	(674,761.4)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,352,893.9	0.0	10,352,893.9
Тайлант үеийн үр дүн	(370,789.8)	0.0	(370,789.8)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,982,104.1	0.0	9,982,104.1
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,982,104.1	0.0	9,982,104.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,982,104.1	0.0	9,982,104.1
Тайлант үеийн үр дүн	1,395,686.8	0.0	1,395,686.8
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,377,790.9	0.0	11,377,790.9



5.4. Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,406,436.0	10,604,438.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,701,239.6	209,401.8
Нийтлэг татварын бус орлого	1,541,836.4	87,112.5
Тусламжийн орлого	159,403.2	122,289.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,705,196.5	10,395,036.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,935,961.9	8,699,132.3
УРСГАЛ ЗАРДАЛ	7,935,961.9	8,699,132.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,747,770.3	8,241,096.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,682,915.6	3,897,362.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,869.0	261,753.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,000.0	96,286.7
Хангамж, бараа материалын зардал	198,182.5	194,978.9
Нормативт зардал	5,000.0	4,950.0
Эд хогшил, урсгал засварын зардал	47,950.2	63,683.1
Томилолт, зочны зардал	82,178.1	85,594.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,216,194.5	3,520,207.3
Бараа үйлчилгээний бусад зардал	182,480.4	116,280.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,191.6	458,035.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,470,474.2	1,905,306.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	946,799.4	2,001,951.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	946,799.4	2,001,951.1
Дотоод эх үүсвэрээр	946,799.4	2,001,951.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(946,799.4)	(2,001,951.1)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	16,717.6	(797.6)
Бусад эх үүсвэр	19,477.4	566.5
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,759.9	1,364.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,540,392.4	(97,442.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	693,244.3	2,233,636.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,233,636.7	2,136,194.2



5.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,402,752.3	10,350,618.1	52,134.2	99.50
УРСГАЛ ЗАРДАЛ	9,551,352.3	9,499,218.1	52,134.2	99.45
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,335,870.1	9,290,623.4	45,246.7	99.52
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,897,513.6	3,897,362.3	151.3	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	264,030.1	261,753.5	2,276.6	99.14
Тэтгэврийн даатгал	113,812.9	144,000.9	(30,188.0)	126.52
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,882.5	96,286.7	8,595.8	91.80
Хангамж, бараа материалын зардал	196,694.5	196,682.9	11.6	99.99
Нормативт зардал	4,950.0	4,950.0	0.0	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	84,811.9	84,809.7	2.2	100.00
Томилолт, зочны зардал	106,760.4	85,594.8	21,165.6	80.17
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,626,087.6	4,613,047.9	13,039.7	99.72
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,579,117.1	4,566,670.0	12,447.1	99.73
Бараа үйлчилгээний бусад зардал	50,139.5	50,135.5	4.0	99.99
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	215,482.2	208,594.7	6,887.5	96.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	45,155.6	42,168.1	2,987.5	93.38
Засгийн газрын гадаад шилжүүлэг	45,155.6	42,168.1	2,987.5	93.38
Бусад урсгал шилжүүлэг	170,326.6	166,426.6	3,900.0	97.71
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	851,400.0	851,400.0	0.0	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,402,752.3	10,347,989.7	54,762.6	99.47
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,297,001.7	10,246,788.5	50,213.2	99.51
Улсын төсвөөс санхүүжих	10,297,001.7	10,246,788.5	50,213.2	99.51
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	105,750.6	101,201.2	4,549.4	95.70
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	3,425.9	(3,425.9)	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,200.0
УРСГАЛ ЗАРДАЛ	99,200.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,200.0
Эд хогшил, урсгал засварын зардал	34,880.0
Багаж, техник, хэрэгсэл	34,880.0
Бараа үйлчилгээний бусад зардал	64,320.0
Бараа үйлчилгээний бусад зардал	50,000.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,320.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99,200.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	99,200.0
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	99,200.0

